

АЖЛЫН ДААЛГАВАР (TERMS OF REFERENCE)

ЗӨВЛӨХИЙН БУС ҮЙЛЧИЛГЭЭ

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨСЛИЙН-МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ”

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт	Мэдээлэл
Төсөл	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (MERESP)
Захиалагч	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Санхүүжүүлэгч	Дэлхийн Банк
Үйлчилгээний төрөл	Зөвлөхийн бус үйлчилгээ
Гэрээний төрөл	Нэгж үнийн бус, үр дүнд суурилсан төлбөртэй гэрээ (Lump Sum Contract)
Хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 2 сар
Байршил	Улаанбаатар хот болон сонгогдсон 1–2 аймаг
Тайлагнах байгууллага	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (IPIU)
Ажлын хэл	Монгол, Англи
Сонгон шалгаруулах арга	Харьцуулалтын арга

2. ҮНДЭСЛЭЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн үндсэн зорилго нь ажил хайгчид, бичил бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлэх, мөн КОВИД-19 цар тахлын үед хөдөлмөр эрхлэгчдэд түр хугацааны дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төсөл хаагдах шатандаа орж байгаа тул төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хүрсэн үр дүн, үзүүлсэн нөлөө, сургамж болон сайн туршлагыг нэгтгэн баримтжуулах, олон нийт болон холбогдох талуудад түгээх шаардлагатай байна.

Иймд төслийн хаалтын үеийн мэдээлэл, сурталчилгааны цогц бүтээгдэхүүн боловсруулах, дүрсжүүлэх, хэвлэн нийтлэх, холбогдох материалыг бүрэн хүлээлгэн өгөх зорилгоор мэргэжлийн байгууллагыг сонгон ажиллуулна.

3. ЗОРИЛГО

Энэхүү үйлчилгээний зорилго нь төслийн үр дүн, үр өгөөж, сайн туршлага, үр шим хүртэгчдийн түүхийг харуулсан өндөр чанартай мэдээлэл, сурталчилгааны багц бүтээгдэхүүнийг монгол болон англи хэлээр боловсруулж, төслийн хаалтын дараа үргэлжлүүлэн ашиглах боломжтойгоор бүх эх материалыг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгөхөд оршино.

ТУСГАЙ ЗОРИЛТ

Үйлчилгээ үзүүлэгч нь дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1. Төслийн үйл ажиллагаа, үр дүн, үр шим хүртэгчдийн түүхийг харуулсан баримтат богино кино болон богино хэмжээний видео контент боловсруулах;
2. Төслийн үр дүн, үзүүлэлтүүдийг нэгтгэсэн товхимол, инфографик, хэвлэмэл болон цахим бүтээгдэхүүн боловсруулах;
3. Төслийн хүрээнд бий болсон дүрс, зураг, дизайны бүх материалыг нэгтгэн архивлах, хүлээлгэн өгөх;
4. Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүний агуулгыг Дэлхийн Банкны урьдчилсан хяналт, үл татгалзах зөвшөөрөл (No Objection)-д хүргүүлэх.

3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Зөвлөх нь дараах гурван ажлын чиглэлийн хүрээнд тодорхойлсон үүрэг даалгаврыг хэрэгжүүлнэ. Зөвлөх нь энэхүү зөвлөх үйлчилгээний хугацаанд Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (НТХН)-тэй нягт хамтран ажиллах бөгөөд төслийн хаалтын арга хэмжээг зохион байгуулах тусдаа гэрээт байгууллагатай тогтмол уялдаа холбоотой ажиллана

3.1 Багц 1. Видео болон гэрэл зургийн бүтээгдэхүүн

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь дараах ажлыг гүйцэтгэнэ:

Баримтат кино

- Төслийн үйл ажиллагаа, үр дүн, үр шим хүртэгчдийн түүхийг харуулсан 3–5 минутын хугацаатай баримтат богино кино бэлтгэх;
- Монгол хэлээр дуу оруулж, англи хадмалтай байх;
- Дотоод болон олон улсын хэрэглээнд ашиглах боломжтой байх.

Богино хэмжээний видео

- 60 секундын урттай дөрвөн ширхэг богино хэмжээний видео контент боловсруулах;
- Facebook, YouTube, Instagram зэрэг цахим сувгуудад түгээхэд тохиромжтой форматтай байх;

- Төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг эсвэл нэг үр шим хүртэгчийн түүхийг онцлон харуулах.

Гэрэл зургийн сан

- Доод тал нь 100 ширхэг өндөр нягтаршилтай гэрэл зураг боловсруулах;
- Зургийг төслийн бүрэлдэхүүн хэсэг, байршил, сэдвээр ангилан тайлбарлах;
- Шинээр авсан болон төслийн архивын зургуудыг нэгтгэх.

Орон нутгийн зураг авалт

- Улаанбаатар хот болон төслийн хэрэгжилт өндөртэй 1–2 аймагт зураг авалт зохион байгуулах;
- Үр шим хүртэгчдээс бичгээр зөвшөөрөл авах;
- Бүх түүхий дүрс бичлэг, B-roll болон боловсруулаагүй гэрэл зургуудыг Захиалагчид хүлээлгэн өгөх.

3.2 Багц 2. Хэвлэл, нийтлэл

Товхимол

- Монгол, англи хэл бүхий нэгтгэсэн (8-12) нүүртэй товхимол боловсруулах;
- Төслийн зорилго, үйл ажиллагаа, үр дүн, нөлөөллийг багтаасан байх;
- PDF болон засварлах боломжтой эх файлаар хүргүүлэх.

Инфографик

- Төслийн гол үр дүнг харуулсан (4-6) ширхэг инфографик боловсруулах;
- Хүйс, байршил, үр шим хүртэгчийн төрлөөр ангилсан мэдээлэл тусгах;
- Тайлан, хэвлэл, цахим орчинд ашиглах боломжтой форматтай байх.

Хэвлэлийн бэлтгэл

- Хэвлэхэд бэлэн PDF файл боловсруулах;
- Захиалагчийн тодорхойлох тоо хэмжээгээр хэвлүүлэхэд шаардлагатай эх бэлтгэлийг хангах;
- Монгол болон англи хэлний мэргэжлийн редактороор хянуулах.

3.3 Багц 3. Бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх

Үйлчилгээ үзүүлэгч дараах материалыг бүрэн хүлээлгэн өгнө:

- Бүх бүтээгдэхүүний эх файл;
- Фото архив;
- Видео архив;

- Түүхий дүрс бичлэгүүд;
- Дизайны загварууд;
- Ашигласан фонтын багц;
- Материалын бүртгэлийн жагсаалт;
- Дахин ашиглах зааварчилгаа.
- Гүйцэтгэлийн эцсийн тайлан (5–10 нүүр);

4. ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ҮР ДҮН

№ Үр дүн	Хугацаа
1 Ажлын төлөвлөгөө, концепц, сториборд	2 дахь долоо хоног
2 Хээрийн зураг авалт дууссан байх	4–5 дахь долоо хоног
3 Товхимол, инфографик бэлтгэгдсэн байх	6–7 дахь долоо хоног
4 Баримтат кино, богино видеонууд, гэрэл зургийн сан	7 дахь долоо хоног
5 Бүх материал хүлээлгэн өгч, эцсийн тайлан ирүүлэх	8 дахь долоо хоног

4.1. ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Үе шат	Төлбөр
Эхлэлийн багц батлагдсаны дараа	30%
Видео, хэвлэлийн бүтээгдэхүүн хүлээн авсны дараа	60%
Эцсийн тайлан, архив хүлээлгэн өгсний дараа	10%

5. ТӨСӨВ

Энэхүү үйлчилгээний нийт төсөв нь:

142,000,000 (Нэг зуун дөчин хоёр сая) төгрөгөөс хэтрэхгүй байна.

Төсөвт дараах зардлууд багтсан байна:

- Мэргэжлийн үйлчилгээний хөлс;
- Зураг авалт, видео үйлдвэрлэл;
- Тоног төхөөрөмжийн ашиглалт;

- Томилолт, замын болон байрны зардал;
 - Хэвлэлийн үйлчилгээ;
 - Орчуулга, редакторын үйлчилгээ;
 - Татвар болон бусад холбогдох зардал.
-

6. Мэргэжил болон туршлага

Энэхүү зөвлөх үйлчилгээг Монгол Улсад бүртгэлтэй харилцаа холбоо, олон нийттэй харилцах (PR) чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага гүйцэтгэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

6.1 Ерөнхий шаардлага

- Монгол Улсад олон нийттэй харилцах, мэдээлэл суртчилгааны болон дүрс бичлэгийн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр таван (5) жилийн туршлагатай байх.
- Монгол Улсын төрийн байгууллагууд болон/эсвэл олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай (Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын байгууллагууд, хоёр талт хамтын ажиллагааны байгууллагууд зэрэг) хамтран ажилласан туршлагатай байх.
- Монгол, Англи хэл дээр мэргэжлийн түвшний мэдээлэл суртчилгааны бүтээгдэхүүн боловсруулж байсан туршлага, чадавхтай байх.
- Монгол Улсын аймаг, орон нутагт ажилласан туршлагатай, Улаанбаатар хотоос гадуур ажилтан болон шаардлагатай тоног төхөөрөмжийг дайчлан ажиллуулах боломжтой байх.

6.2 Багийн бүрэлдэхүүний шаардлага

- Багийн ахлагч / Олон нийттэй харилцах, сэтгүүл зүй – холбогдох чиглэлээр дор хаяж долоо (7) жилийн ажлын туршлагатай, Монгол болон Англи хэлний чөлөөтэй мэдлэгтэй байх.
- Дүрс бичлэгийн оператор / Эвлүүлэгч – баримтат кино, видео контент үйлдвэрлэлийн туршлагатай байх.
- График дизайнер – хэвлэлийн болон хэвлэмэл бүтээгдэхүүн боловсруулах туршлагатай байх.
- Гэрэл зурагчин – орон нутагт ажилласан туршлагатай, Улаанбаатар хотоос гадуурх ажлын жишээ бүхий бүтээлийн сантай байх.

6.3 Хэлний мэдлэг

- Монгол болон Англи хэлний ажлын түвшний мэдлэг заавал байх.
- Төслийн үр шим хүртэгчдэд чиглэсэн бүх төрлийн контент болон орчуулгын ажилд Монгол хэлний найруулга, соёлын онцлог илэрхийлэх хэллэгийн зохистой хэрэглээний талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

6.4 Давуу тал болох шалгуур үзүүлэлтүүд

- Дэлхийн банк болон бусад хөгжлийн түнш байгууллагуудын мэдээлэл суртчилгааны ажил хийж байсан туршлагатай бол давуу тал болно.
 - Энэхүү зөвлөх үйлчилгээний хугацаа болон зардлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх төслийн чиглэлээр зураг, дүрс бичлэгийн архив, мэргэжлийн харилцааны сүлжээ, эсхүл дизайны бэлэн загваруудтай байх.
-

7. Төслөөс үзүүлэх дэмжлэг,

Төслийг хэрэгжүүлэх нэгж (НТХН) нь зөвлөхөд дараах мэдээлэл, дэмжлэгийг цаг тухайд нь үзүүлнэ:

- Төслийн хаалтын тайлан, хяналт-шинжилгээний мэдээлэл болон төсөлтэй холбоотой бусад баримт бичиг, түүнчлэн төслийн үр дүн, хөгжлийн бодлогод оруулсан хувь нэмрийн талаарх үндсэн мэдээлэл.
 - Хэрэгжүүлэгч яам, аймаг орон нутгийн хамтрагч байгууллагууд болон төслийн үр шим хүртэгч иргэд, олон нийттэй холбогдох, хамтран ажиллах зохицуулалтын дэмжлэг.
 - Төслийн хүрээнд өмнө нь боловсруулсан зураг, дүрс бичлэг, хэвлэмэл болон бусад харилцаа холбооны материал зэрэг одоо байгаа мэдээллийн сан.
 - Зөвлөх үйлчилгээний ажлыг уялдуулах, тайлан бүтээгдэхүүнийг хянах, санал өгөх, баталгаажуулах үүрэг бүхий НТХН-ийн холбогдох ажилтан.
 - Төслийн хаалтын арга хэмжээг зохион байгуулах тусдаа гэрээт байгууллагын холбоо барих мэдээлэл болон хамтын ажиллагааны зохицуулалт.
-

8. Тайлагнал ба хяналт

Зөвлөх нь Төслийн зохицуулагч эсхүл НТХН-ээс томилогдсон холбогдох ажилтанд шууд тайлагнана. Зөвлөх нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Гэрээ байгуулснаас хойш нэг (1) долоо хоногийн дотор НТХН-тэй эхлэлийн уулзалтыг зохион байгуулах.
- Зөвлөх үйлчилгээний хугацаанд долоо хоног бүр ажлын явцын товч бичгэн тайлан ирүүлэх.
- Ажлын явцыг хэлэлцэх, боловсруулсан материалуудыг хянан баталгаажуулах зорилгоор ТХН-тэй дор хаяж хоёр долоо хоног тутам уулзалт зохион байгуулах.